УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 06 ТООТ ТОГТООЛООР БАТЛАВ
ЕРӨНХИЙЛӨГЧ ..... А.БАТДАВАА

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АРГ
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗ
ТГС2127 7/27
Хуулийн этгээдийн улсын бүртгэл
дугаар 9072015027
2025 12 25
Бүртгэсэн: Улсын (захиргаа) бүртгэгч

“МОНГОЛЫН ПАРАГЛАЙДИНГИЙН ХОЛБОО”
ГҮТББ-ЫН ДҮРЭМ

НЭГ ДҮГЭЭР БҮЛЭГ:
НЭГ ДҮГЭЭР ЗҮЙЛ: НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Байгууллагын нэр: **Монголын Параглайдингийн Холбоо**, товчлол нь МПХ /цаашид энэ дүрэмд товчлолыг хэрэглэнэ/, Англи хэлээр: **Mongolian Paragliding Association**, товчлол нь **MPGA**

1.2 Байгуулагдсан он, сар, өдөр: 2016 оны 10-р сарын 06-ны өдөр

1.3 Олон улсын нэршлийн дагуу “Параглайдинг” гэсэн нэр томьёог үйл ажиллагаандаа түлхүү хэрэглэнэ МПХ нь параглайдингийн спортыг сонирхогч, хичээллэгч, дэмжигчдийн сайн дурын үндсэн дээр үйл ажиллагаагаа нэгтгэн байгуулагдсан, гишүүнчлэлтэй, гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага юм.

1.4 Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 30-р хороо, АОС 82-2

1.5 Харилцах утас: 1) 88117097 2) 99086452 3) 90002333

1.6 МПХ нь Монгол улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаа явуулна.

ХОЁР ДУГААР ЗҮЙЛ: ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЗАРЧИМ

2.1 МПХ нь Монгол улсын төрийн бус байгууллагын тухай болон бусад холбогдох хууль тогтоомжуудыг удирдлага болгон өөрийн дүрмийн хүрээнд төр засгийн болон бусад төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдтэй хамтран ажиллана

2.2 Төрөөс баримтлах нийтийн биеийн тамир, спортыг бүх талаар хөгжүүлэх бодлогын хүрээнд төр захиргааны байгууллагуудтай хамтран ажиллана

2.3 Дэлхийн Агаарын Спортын Холбоо /FAI/, Олон улсын Параглайдингийн нисгэгч, Инструкторуудын холбоо (APPI), Монголын Агаарын Спортын Холбоо /МАСХ/ болон бусад олон улсын байгууллага, гадаад орнуудын холбогдох холбоо, байгууллагуудтай параглайдингийн спортын чиглэлээр хоёр талын болон олон талт хамтын ажиллагаагаа улам эрчимжүүлж, хамтран ажиллана

2.4 МПХ-ны үйл ажиллагаа нь улс төр, шашнаас ангид байж, улс төрийн хүчин, хувь хүн, компани, бусад байгууллагаас хараат бус байна

2.5 МПХ-ны үйл ажиллагаа нь нас, хүйс, яс үндэс, гарал үүсэл, арьс өнгө, шашин шүтлэг, үзэл бодол, ялгаатай байдал, алдар цолоор ялгаварласан шинжтэй байж болохгүй

ХОЁР ДУГААР БҮЛЭГ:
ГУРАВ ДУГААР ЗҮЙЛ: МПХ-НЫ ЭРХЭМ ЗОРИЛГО

3.1 Монгол улсад Параглайдингийн спортыг хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх замаар параглайдингийн спортын хөгжлийг олон улсын түвшинд хүргэх, авьяаслаг, ур чадвартай тамирчин, дасгалжуулагч, шүүгчдийг бэлтгэж дэмжих, параглайдингийн спортоор дамжуулан эх орноо дэлхий дахинд сурталчлан таниулах, олон улсын тэмцээн уралдаанд оролцон амжилт гаргахад МПХ-ны эрхэм зорилго оршино.

ДӨРӨВ ДҮГЭЭР ЗҮЙЛ: МПХ-НЫ ЗОРИЛТ

4.1 Параглайдингийн спортыг сонирхогч, хичээллэгч, дэмжигчдийн үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулж, удирдан чиглүүлэх

4.2 Монгол улсын иргэний нисэхийн хууль дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулах

4.3 Нислэгийн аюулгүй байдлыг хангаж ажиллахтай холбоотой дүрэм, журам, заавар боловсруулан батлах, хэрэгжүүлэх, мөрдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах

4.4 Параглайдингийн спортын цол, зэргийн журам боловсруулж, хэрэгжүүлэх

4.5 Үндэсний инструктор багш, шүүгч, тамирчдыг гэрчилгээжүүлэх, спортын лиценз олгох

4.6 МПХ нь мэргэжлийн зөвлөлүүдээрээ дамжуулан инструктор, дасгалжуулагч, шүүгч бэлтгэх

4.7 Дэлхийн түвшинд амжилт гаргахуйц шигшээ багийн тамирчдыг тодруулж, багийн болон хувийн өндөр амжилт гаргах боломжтой тамирчдыг бэлтгэж, олон улсын тэмцээнд оролцоход нь дэмжлэг үзүүлэх

4.8 Жил бүр уламжлал болон зохион байгуулдаг параглайдингийн улсын аварга шалгаруулах тэмцээнийг цэгт газардах болон кросскантри төрлүүдээр, гишүүн клубүүдтэй хамтран цуврал тэмцээнүүдийг зохион явуулах, зохион байгуулалт, төлөвлөлтөд дэмжлэг үзүүлэх

4.9 Өөрийн оронд олон улсын чанартай тэмцээн уралдаан, спортын арга хэмжээ зохион байгуулахад шаардлага хангахуйц хөөрөх, газардах талбайнуудыг төрийн удирдлагын байгууллага, орон нутгийн засаг захиргааны нэгжүүд, хувь хүмүүс, албан байгууллагатай хамтран хөгжүүлэх

4.10 Дэлхийн агаарын спортын холбоо /FAI/, Азийн параглайдингийн холбоо болон бусад олон улс, гадаадын байгууллагуудтай параглайдингийн спортыг хөгжүүлэх, материаллаг баазыг бэхжүүлэх чиглэлээр хамтын ажиллагаагаа хөгжүүлэх гадаад бодлого баримтлах

МПХ-ны бие даасан байдлыг бэхжүүлэх зорилгоор төр, засгийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, гадаадын хандивлагч байгууллага, хувь иргэнтэй гэрээ хэлцэл хийж, хамтран ажиллах

ГУРАВ ДУГААР БҮЛЭГ:
ТАВ ДУГААР ЗҮЙЛ: МПХ-НЫ ЭРХ, ҮҮРЭГ

5.1 Параглайдингийн спортыг хөгжүүлэхэд баримтлах бодлого, урт, дунд, богино хугацааны хөтөлбөр, төсөл, төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх

5.2 Нийт гишүүдийнхээ хууль ёсны эрх ашиг, сонирхлыг хамгаалах

5.3 Спортын өндөр амжилт гаргасан дасгалжуулагч, тамирчин, шүүгч, параглайдингийн спортыг хөгжүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан байгууллага, иргэдийг төр, засгийн шагналд нэр дэвшүүлж тодорхойлох, шагнах

5.4 МПХ нь параглайдингийн клубүүд болон хувь хүмүүсийг гишүүнээр элсүүлж, мэргэжлийн удирдлагаар хангах, арга зүйн заавар, зөвлөмж, гарын авлага, мэдээллээр хангах, үйл ажиллагаагаа явуулахад нь дэмжлэг, мэргэжлийн туслалцаа үзүүлэх, олон нийтэд хандсан үйл ажиллагааны зохион байгуулалтад аюулгүй ажиллагааны хяналт тавих

5.5 МПХ-ны ёс зүйн хэм хэмжээ болон дүрэм журмыг зөрчсөн гишүүн байгууллага болон хувь хүнийг гишүүнчлэлээс хасах, инструкторын эрхийг тодорхой хугацаагаар түдгэлзүүлэх, шүүгчийг тодорхой хугацаагаар шүүгчээр ажиллах эрхийг түдгэлзүүлэх болон цуцлах хүртэл арга хэмжээ авах

5.6 Монголын агаарын спортын холбоо /МАСХ/-гоор дамжуулан Дэлхийн агаарын спортын холбоо болон агаарын чөлөөт нислэгийн спортын олон улс, тив, дэлхийн байгууллагуудын гишүүн байх, элсэх, гарах, нэгдэх, ажиглагчаар оролцох, гишүүний татвар төлөх

5.7 FAI-ийн ерөнхий чуулган, бусад хурал, зөвлөгөөнд оролцох, санал хүсэлтээ хүргүүлэх, олон улсын тэмцээнд оролцох, эх орондоо олон улсын чанартай тэмцээн, арга хэмжээ зохион байгуулах

5.8 Олон улс, тив, дэлхийн тэмцээн, Олимпын наадамд оролцуулах параглайдингийн шүүгч, үндэсний шигшээ баг, тамирчдын бүрэлдэхүүнийг тодорхойлон мэдүүлэг өгч, батламжлан оролцуулах

5.9 Олон улс, тив, дэлхийн уралдаан тэмцээн болон олон улсын байгууллагын хурал, зөвлөгөөн, семинар, бусад арга хэмжээнд оролцох, өөрийн оронд хүлээн авч зохион байгуулах

5.10 МПХ-ны шаардлагыг хангасан дотоод болон гадаадад гэрчилгээжсэн /ИНД-149,106 -р дүрмээр гэрчилгээжсэн/ МПХ-н гишүүн клубийн тандем нисгэгчдэд арилжааны тандем нислэгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, цуцлах

5.11 МПХ-ны журмын шаардлагыг хангаж дотоод болон гадаадад гэрчилгээжсэн инструктор багштай /ИНД-149,106-р гэрчилгээжсэн/ МПХ-ны гишүүн клуб, хуулийн этгээдэд параглайдерын нисгэгчийн анхан, дунд, ахисан шатны сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, цуцлах

ДӨРӨВ ДҮГЭЭР БҮЛЭГ:
ЗУРГАА ДУГААР ЗҮЙЛ: МХПН-ИЙН УДИРДЛАГЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

6.1 **МПХ-ны удирдлагын бүтэц нь:**

6.1.1 МПХ-ны бүх гишүүдийн хурал

6.1.2 Удирдах зөвлөл

6.1.3 Ерөнхийлөгч

6.1.4 Ерөнхий нарийн бичгийн дарга

6.1.5 Тэмцээний зөвлөл, мэргэжлийн зөвлөл, шүүгчдийн зөвлөл, санхүү, маркетинг олон нийттэй харилцах зөвлөл, хяналтын зөвлөл

6.1.6 Гишүүнчлэл бүхий байгууллага, хувь гишүүд

ДОЛДУГААР ЗҮЙЛ: МПХ-НЫ БҮХ ГИШҮҮДИЙН ХУРАЛ

7.1 МПХ-ны бүх гишүүдийн хурал нь жилд нэг удаа хуралдана

7.2 Бүх гишүүдийн хурлын товыг нэг сараас доошгүй хугацааны өмнө МПХ-ны удирдах зөвлөлөөс тогтоож, зарлана

7.3 Хуралд МПХ-ны гишүүнчлэл бүхий байгууллагаас төлөөлөгчид, хувь гишүүд оролцоно

7.4 Шаардлагатай тохиолдолд бүх гишүүдийн хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулж болно /бүх нийтийн хөл хорио тогтоосон тохиолдолд/

7.5 Бүх гишүүдийн хуралд сонгох төлөөлөгчдийн тоог МПХ-ны удирдах зөвлөлөөс тогтооно

7.6 **МПХ-ны бүх гишүүдийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэнэ Үүнд:**

7.6.1 МПХ-ны үйл ажиллагааны тайлан

7.6.2 Хяналтын зөвлөлийн тайлан

7.6.3 Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах

7.6.4 МПХ-ны Ерөнхийлөгчийг сонгох

7.6.5 МПХ-ны удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг сонгох

7.6.6 МПХ-ны удирдах зөвлөлийн гишүүдийн 1/3 (гуравны нэг)-ийн саналаар ээлжит бус бүх гишүүдийн хурлыг хуралдуулж болно

НАЙМ ДУГААР ЗҮЙЛ: МПХ-НЫ УДИРДАХ ЗӨВЛӨЛ

8.1 Удирдах зөвлөл нь бүрэн эрхийнхээ хугацаанд МПХ-ны үйл ажиллагааг удирдана

8.2 МПХ-ны бүх гишүүдийн хурлын бэлтгэл ажлыг ханган зохион байгуулан хуралдуулна

8.3 МПХ-ны удирдах зөвлөл доод тал нь 9 гишүүнтэй байх ба гишүүн байгууллага бүрээс томилогдсон 1 гишүүнийг удирдах зөвлөлд шууд оруулах эсэхийг бүх гишүүдийн хурлын дийлэнх олонхын саналаар шийдвэрлэнэ. Бусад орон тоонд бүх гишүүдийн хурлын төлөөлөгчдөөс нэр дэвшүүлж, удирдах зөвлөлөөс тогтоосон санал өгөх квоттой гишүүдийн олонхын саналаар сонгоно

8.4 Удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 4 жил байна. Нэг удаа улируулан сонгож болно

8.5 Удирдах зөвлөл нь улиралд нэгээс доошгүй удаа хуралдаж, хэлэлцсэн асуудлаар тэмдэглэл хөтөлж, шаардлагатай гэж үзвэл тогтоол гаргана

8.6 Удирдах зөвлөлийн хурал нь гишүүдийн ердийн олонх оролцсон тохиолдолд хүчинтэйд тооцогдоно. Асуудлыг хуралд оролцож байгаа гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ

8.7 Удирдах зөвлөл нь холбооны үйл ажиллагааны хүрээнд дүрэм, журам боловсруулж батлах, мөрдүүлэх, хяналт тавих үүргийг хүлээнэ

8.8 **Бүрэн эрхийн хугацаанаас өмнө удирдах зөвлөлийн гишүүний эрх, үүрэг дуусгавар болох, түдгэлзүүлэх:**

8.8.1 Нас барсан, сураггүй алга болсонд тооцогдсон

8.8.2 Өөрийн хүсэлтээр гишүүнээс татгалзах

8.8.3 Гэмт хэрэгт сэжигтнээр татагдсан

8.8.4 Гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон

8.8.5 Холбооны эсрэг үйл ажиллагаа явуулсан буюу оролцсон байж болох үйлдлийг шалгаж тогтоох хүртэл

8.8.6 Энэхүү дүрмээр хориглосон зүйлийг хийсэн

8.8.7 Удирдах зөвлөлийн гишүүний үүргээ хангалттай биелүүлээгүй, тухайн жилд товлогдсон удирдах зөвлөлийн хуралд 2 болон түүнээс дээш удаа хүндэтгэх шалтгаангүйгээр оролцоогүй тохиолдолд удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэж, хурлын протоколд тэмдэглэсний дагуу бичгээр сануулга өгөн түтгэлзүүлэх

8.8 **Бүрэн эрхийн хугацаанд удирдах зөвлөлийн гишүүнийг нөхөн сонгох:**

8.8.1 Гишүүн байгууллагаас томилогдсон гишүүний оронд тухайн байгууллагаас шинээр томилсон гишүүнийг удирдах зөвлөлийн гишүүдийн олонхын саналаар

8.8.2 Бүх гишүүдийн хурлаас нэр дэвшиж сонгогдсон гишүүний оронд тухайн санал хураалтаар дараагийн хамгийн өндөр санал авсан нэр дэвшигчийг удирдах зөвлөлд нөхөн оруулна

ЕС ДҮГЭЭР ЗҮЙЛ: МПХ-НЫ ЕРӨНХИЙЛӨГЧ

9.1 Ерөнхийлөгчид нэр дэвшигч нь параглайдингийн спортыг хөгжүүлэх, санхүү, эдийн засгийн чадавхыг нь дээшлүүлэх чин эрмэлзэлтэй, удирдан зохион байгуулах чадвартай Монгол улсын иргэн, МПХ -ны удирдах зөвлөлийн гишүүн байна

9.2 Ерөнхийлөгчид нэр дэвшигч нь өөрийн үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг бүх гишүүдийн хуралд танилцуулна

9.3 МПХ-ны Ерөнхийлөгчийг удирдах зөвлөлөөс баталсан дэгийн дагуу бүх гишүүдийн хурлаар 2 жилд нэг удаа санал өгөх эрхтэй гишүүдийн ердийн олонхын санал хураалтаар сонгоно

9.4 МПХ-ны ерөнхийлөгчөөр удаа дараа сонгогдон ажиллаад өөрчлөгдсөн тохиолдолд “Хүндэт ерөнхийлөгч”-өөр өргөмжлөгдөж, зөвлөх эрхтэй байна

9.5 **МПХ-ны Ерөнхийлөгчийн эрх, үүрэг:**

9.5.1 Ерөнхийлөгч нь удирдах зөвлөлийн хурлыг зарлан хуралдуулна

9.5.2 Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнээс ерөнхий нарийн бичгийн даргыг нэр дэвшүүлж, удирдах зөвлөлийн олонхын саналаар сонгуулна

9.5.3 МПХ-г гадаад, дотоодод төлөөлнө

9.5.4 Шаардлагатай гэж үзвэл зарим орон тоог бий болгож, тэдгээрийн ажлын хуваарь, цалингийн хэмжээг тогтоож, ажилд авах, чөлөөлөх тушаал гаргаж шийдвэрлэх

9.5.5 Параглайдингийн спортын шүүгч, тамирчин, инструктор, дасгалжуулагч, аж ахуйн нэгж, гишүүн байгууллага, хуулийн этгээдтэй байгуулсан гэрээ хэлэлцээрийг батлах

9.5.6 Удирдах зөвлөлийн хурлаар батлагдсан үйл ажиллагааны хүрээнд төсвийг захиран зарцуулах

9.5.7 Энэ дүрэм болон бусад холбогдох дүрэм, журмыг зөрчсөн гишүүн байгууллагын арилжааны нислэг, сургалтын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл болон хувь гишүүний нисгэгчийн үнэмлэхийг тодорхой хугацаанд түдгэлзүүлэх, цуцлах, зөрчлийг арилгах шаардлага тавих

9.5.8 МПХ-ны бүх гишүүдийн хуралд ажлаа тайлагнах

9.6 **Ерөнхийлөгчийг чөлөөлөх:**

9.6.1 Эрүүл мэндийн болон бусад шалтгаанаар ажиллах боломжгүй болсон, өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх хүсэлт гаргасан тохиолдолд удирдах зөвлөлийн шийдвэрээр үүрэгт ажлаас нь чөлөөлнө

9.6.2 Ерөнхийлөгчийг бүрэн эрхийн хугацаанаас нь өмнө чөлөөлөх саналыг удирдах зөвлөлийн нийт гүшүүдийн дийлэнх олонхоор гаргаж, бүх гишүүдийн хурлаар шийдвэрлэнэ

9.6.3 Ерөнхийлөгч сонгуульт хугацаанаас өмнө ажил үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд түүний ажил үүргийг бүх гишүүдийн хурлаар шинэ ерөнхийлөгчийг сонгох хүртэл Ерөнхий нарийн бичгийн дарга түр орлон гүйцэтгэнэ

АРАВ ДУГААР ЗҮЙЛ: МПХ-НЫ ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

10.1 Ерөнхий нарийн бичгийн дарга нь дээд боловсролтой, параглайдингийн спортыг хөгжүүлэх чин эрмэлзэлтэй, багаар ажиллах, удирдан зохион байгуулах чадвартай, туршлагатай МПХ-н гишүүн Монгол улсын иргэн байна

10.2 Ерөнхий нарийн бичгийн даргыг Ерөнхийлөгчийн санал болгосноор удирдах зөвлөлийн хурлаар сонгож, чөлөөлөх бөгөөд орон тооны байна. Удирдах зөвлөлийн гишүүн саналын эрхтэйгээр сонгогдох эрхтэй

10.3 Ерөнхий нарийн бичгийн даргын эрх, үүрэг:

10.3.1 МПХ-ны өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулж, удирдах зөвлөлөөс олгосон эрхийн хүрээнд шийдвэр гаргаж, удирдах зөвлөлд ажлаа тайлагнах, санал оруулах

10.3.2 Дасгалжуулагч, зааварлагч багш, шүүгч, тандем нисгэгчид, гишүүн байгууллага хувь гишүүдтэй хэлцэл хийх

10.3.3 Жилийн ажлын болон спортын календарчилсан төлөвлөгөө, төсөв, орон тоо, бодлогын чанартай бичиг баримтыг боловсруулан бэлтгэж, удирдах зөвлөлийн хуралд оруулан хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх

10.3.4 Удирдах зөвлөлийн дэргэдэх зөвлөлийн багуудыг мэдээллээр хангах, хамтран ажиллах, тэдний асуудлыг холбогдох хүмүүст танилцуулж шийдвэрлүүлэх

10.3.5 МПХ-ны тэмдэг, туг далбаа, бичиг баримт, бусад зүйлсийг үйл ажиллагаанд ашиглах, хадгалах, хамгаалах, архивлах, өмч хөрөнгийг бүртгэн хяналт тавих

10.3.6 Жилийн эцсийн ажлын болон санхүүгийн тайлан тэнцлийг гаргуулж, удирдах зөвлөлийн хуралд оруулах

10.3.7 Гадаад, дотоодод зохион байгуулагдах тэмцээнийг хариуцаж ажиллах

10.3.8 Холбооны гишүүн хувь хүн албан байгууллагаас ирсэн хүсэлт, гомдол, саналыг ерөнхийлөгчид уламжлан удирдах зөвлөлд санал оруулж, шийдвэрлүүлэх

АРВАН НЭГ ДҮГЭЭР ЗҮЙЛ: МПХ-НЫ УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ЗӨВЛӨЛ, БАГ

11.1 **Мэргэжлийн зөвлөл:**

11.1.1 Зөвлөлийн бүрэлдэхүүнд олон улс, тив, дэлхийн чанартай тэмцээнд тамирчид нь шалгаран оролцдог, үндэсний шигшээ багийн тамирчдыг дасгалжуулдаг, тамирчдынхаа өдөр тутмын бэлтгэл, сургалтыг хариуцдаг мэргэжлийн инструктор, дасгалжуулагчид орно

11.1.2 Мэргэжлийн туслах инструктор, инструктор, мастер инструктор болон дасгалжуулагч нь олон улсын параглайдингийн нисгэгч, инструкторуудын холбоо (APPI) -ны шаардлагын дагуу гэрчилгээжсэн байна

11.1.3 Инструктор, дасгалжуулагчийн зөвлөлд 3 /гурав/ болон түүнээс дээш 5 /тав/ хүртэлх туслах инструктор, инструктор, мастер инструктор хүн байна. Бүрэлдэхүүн ахлагчийг удирдах зөвлөлөөс томилно. Дотоод журам, ажлын чиглэлийг удирдах зөвлөлөөр батлуулна

11.1.4 Мастер инструктор болон инструктор нь үндэсний шигшээ багийн ахлах дасгалжуулагчид нэр дэвшинэ

11.2 **Шүүгчдийн зөвлөл:**

11.2.1 МПХ-ноос баталсан төлөвлөгөөний дагуу дотоодод зохиогдох тэмцээнд ажиллах шүүгчдийн бүрэлдэхүүнийг томилох, заавар зөвлөмж өгөх

11.2.2 Дэлхийн агаарын спортын холбооноос баталсан параглайдингийн шүүгч бэлтгэх сургалтын материал, гарын авлагыг мөрдлөг болгон шүүгчийн сургалт, давтан сургалт зохион байгуулах, шүүгчдийг хамруулах, бүрэлдэхүүнийг шинэчилж сэлгэх, шүүгчийн үнэмлэх олгох, МПХ-ны шүүгчдийн жагсаалт гаргаж, хагас жил тутамд шинэчлэн вэбсайт, сошиалд нийтлэх

11.2.3 Тэмцээн шүүхдээ зөвхөн дэлхийн агаарын спортын холбооны дүрмийг хэрэглэх, түүнд орсон нэмэлт, өөрчлөлтүүдийг дасгалжуулагч, тамирчдад танилцуулж мөрдүүлэх

11.2.4 Шүүгчдийн зөвлөл нь 3 /гурван/ хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд бүрэлдэхүүн ахлагчийг удирдах зөвлөлөөс томилно, дотоод дүрэм, журам, ажлын чиглэлийг удирдах зөвлөлөөр батлуулна

11.3 **Санхүү, Маркетинг олон нийттэй харилцах зөвлөл:**

11.3.1 МПХ-ны үйл ажиллагаа, мэдээ мэдээлэл, спортоо МПХ-ны вэб хуудас, сошиал медиа, бусад хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдээр байнга сурталчилна

11.3.2 Удирдах зөвлөл болон дасгалжуулагч, тамирчдыг параглайдингийн спортын холбогдолтой мэдээллээр хангана

11.3.3 Тэмцээн, арга хэмжээ зохион байгуулалтыг идэвхжүүлэх

11.3.4 МПХ-нд санхүүгийн төсөв бүрдүүлэхэд анхаарч ажиллах, спортоороо дамжуулан албан байгууллагуудын реклам сурталчилгаа, холбогдох арга хэмжээнд оролцох зэргээр холбооны үйл ажиллагаанд дэмжлэг болох

11.3.5 МПХ-ны дотоод болон гадаад хөрөнгө оруулалттай холбоотой ажлуудыг хийх, хөрөнгө оруулалт татах

11.3.6 Санхүү, Маркетингийн баг нь 3-н хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд багийн ахлагч нь мэргэжлийн ажлын дадлага, туршлагатай байна. Удирдах зөвлөлөөс бүрэлдэхүүн, ахлагчийг томилон ажиллуулна

11.4 **Тэмцээний зөвлөл:**

11.4.1 Тэмцээний зөвлөл нь олон улсын категорид хамаарах болон бусад төрлөөр тухайн жилд МПХ-с эх орондоо зохион байгуулагдах тэмцээний хуваарийн төлөвлөгөөг гарган удирдах зөвлөлийн хурлаар батлуулж, олон нийтэд танилцуулна

11.4.2 Тухайн жилд олон улсад зохион байгуулагдах тэмцээний хуваарийн дагуу үндэсний шигшээ багийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулж, тэмцээнд оролцох үйл ажиллагааг зохион байгуулна

11.4.3 Гишүүнчлэлтэй клуб, тамирчдын хүсэлтийн дагуу олон улсын тэмцээн уралдаанд оролцоход нь мэргэжлийн туслалцаа үзүүлнэ

11.4.4 МПХ-с тухайн жилд зохион байгуулсан тэмцээний үр дүнгийн дагуу тамирчдын үндэсний чансааг тогтоож гишүүдэд танилцуулна

11.4.5 Тэмцээний зөвлөл нь 3-н хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд багийн ахлагчийг удирдах зөвлөлөөс томилон ажиллуулна

11.4.6 Тэмцээний зөвлөл нь олон улсын параглайдингийн нисгэгч, инструкторуудын холбоо (APPI), Дэлхийн агаарын спортын холбооны дүрэмд нийцсэн тэмцээн уралдаан зохион байгуулах дотоодын дүрэм, журам боловсруулан удирдах зөвлөлөөр батлуулан хэрэгжүүлнэ

11.5 **Хяналтын зөвлөл:**

11.5.1 Хяналтын зөвлөл нь МПХ-ны дотоод дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт тавих бөгөөд МПХ-ны үйл ажиллагаанд сөрөгөөр нөлөөлж болохуйц аливаа зөрчил, алдаа, дутагдалтай нөхцөл байдлыг шалгах, илрүүлэх, таслан зогсоох замаар дүрэм, журмын хэрэгжилтийг хангуулж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх ерөнхий чиг үүрэгтэй ажиллана.

11.5.2 Хяналтын зөвлөлийн ахлах болон бүрэлдэхүүнийг /3 хүн/ МПХ-ны удирдах зөвлөлийн шийдвэрээр томилж, чөлөөлнө.

11.5.3 Хяналтын зөвлөл нь удирдах зөвлөлөөс баталсан хүрээнд ажиллана

11.5.4 Дүрмийн хэрэгжилтийг хангах, хянах, гишүүн байгууллагууд болон клубүүдээс зохион явуулж буй төлбөртэй болон төлбөргүй сургалт болон зорчигчтой нислэгийн үйл ажиллагаанд МПХ болон ИНД холбогдох дүрмийн нийцэж буй эсэхэд хяналт тавих

11.5.5 Нисгэгчид, тамирчид, дасгалжуулагч, инструктор, шүүгчдэд аюулгүйн зааварчилгаа, дотоод дүрэм журмыг тогтмол дагаж мөрдүүлэн хэвшүүлэх, хэрэгжилтэнд хяналт тавих

АРВАН ХОЁР ДУГААР ЗҮЙЛ: МПХ-НЫ ГИШҮҮН БАЙГУУЛЛАГА, ХУВЬ ХҮН

12.1 МПХ-ны 2021 оны 12-р сарын 03-ны өдөр батлагдсан гишүүнчлэлийн журмын дагуу гишүүнээр элссэн, параглайдинг, чөлөөт нислэгийн спортын чиглэлээр байгуулагдсан төрийн бус байгууллага, хязгаарлагдмал хариуцлагатай компанийг гишүүн байгууллага, хувь гишүүнээр элссэн нисгэгчийг гишүүн гэж үзнэ.

12.2 МПХ-ны гишүүн клубүүд болон байгууллагууд, гишүүн нисгэгч нар нь МПХ-ны удирдах зөвлөлд тусгай зөвшөөрлийн дагуу зохион байгуулсан шинэ гишүүний сургалт дадлага, тэмцээн уралдаан, арилжааны чиглэлээр үйлдсэн нислэгийн тоон мэдээлэл зэрэг тухайн жилд хийж гүйцэтгэсэн ажлын мэдээлэл, тайланг дараа оны 1 дүгээр сарын 15-д багтаан МПХ-ны ерөнхий нарийн бичгийн даргаар дамжуулан хүргүүлнэ

АРВАН ГУРАВ ДУГААР ЗҮЙЛ: МПХ-НЫ ГИШҮҮНИЙ ЭРХ, ҮҮРЭГ

13.1 МПХ-ны 2021 оны 12-р сарын 03-ны өдөр батлагдсан гишүүнчлэлийн журмыг хүлээн зөвшөөрч, элсэхийг хүссэн Монгол улсын иргэн, хуулийн этгээдийг нийгмийн гарал үүсэл, яс үндэс, боловсрол, шашин харгалзахгүйгээр МПХ-ны гишүүнээр элсэж болно

13.2 Гишүүн нь МПХ -ны дүрэм, удирдах зөвлөлөөс баталсан журмуудыг чанд сахиж, ДАСХ /FAI/, Параглайдерын нисгэгч, багш дасгалжуулагч нарын холбоо /APPI/, МАСХ, ИНД-ийг мөрдлөг болгон биелүүлнэ

13.3 Дэлхийн допингийн эсрэг дүрэм, Монгол улсын допингийн эсрэг дүрмийг мөрдөх

13.4 МПХ-ноос олгосон болон холбооны хөрөнгөөр худалдан авсан тоног төхөөрөмж, нислэгийн хөөрөх, газардах талбай болон эд материал, хэрэгслийг ариг гамтай, зөвхөн параглайдингийн спортын болон тэмцээний зориулалтын дагуу хэрэглэх, өөрийн буруугаас болж хохирол учруулсан тохиолдолд учирсан хохирлыг барагдуулна

13.5 Олон улс, тив, дэлхийн тэмцээнд Монгол улсын нэрийн өмнөөс оролцох шигшээ багийн бүрэлдэхүүнд орсон тамирчид, дасгалжуулагчид, албаны хүмүүс нь зохион явагдаж буй тэмцээний бэлтгэл, нээлт, хаалтын ажиллагаа, шагнал гардуулах ёслол, хэвлэлийн бага хурал болон бусад арга хэмжээнд МПХ-с олгосон хувцастай оролцоно

13.6 МПХ-ны гишүүн байгууллага, хувь гишүүн, багш дасгалжуулагч, тамирчин нь ивээн тэтгэгч байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулж, гэрээний нөхцөлийн дагуу байгууллагын реклам, зар сурталчилгаанд оролцох, нэрийн тамирчин болох эрхтэй

13.7 Гишүүн байгууллагын, клубийн тамирчид, нисгэгчид, багш, шүүгчид нь гадаад руу параглайдингийн тэмцээн, бэлтгэл дасгалжуулалт, цугларалт, сургалт семинарт явах тохиолдолд МПХ-нд урьдчилж мэдэгдэнэ

13.8 Гишүүд нь МПХ-ны зөвшөөрөлгүйгээр МПХ-г төлөөлөн гадаад, дотоодын аль нэг байгууллага, компани, ДАСХ /FAI/, МАСХ болон холбогдох бусад олон улс, тив, дэлхийн байгууллагуудад хандах, гэрээ, хэлцэл хийхгүй байх

13.9 МПХ-ны гишүүн тамирчид FAI-ийн спортын лиценз авахдаа МПХ-р дамжуулан МАСХ-д хандана

13.10 Гишүүн нь МПХ-ны аль нэг байгууллагад сонгох сонгогдох эрхтэй бөгөөд МПХ-нд татвар төлөх үүрэгтэй. Жилд төлөх татварын хэмжээг МПХ-ны удирдах зөвлөлөөс тухай бүр тогтооно

13.11 МПХ-ноос зохион байгуулж буй сургалт, тэмцээн, арга хэмжээнд идэвхтэй оролцох

АРВАН ДӨРӨВ ДҮГЭЭР ЗҮЙЛ: МПХ-НЫ ГИШҮҮНИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ГИШҮҮНЧЛЭЛЭЭС ХАСАХ

14.1 **Гишүүнчлэлээс түр түдгэлзүүлэх:**

- Гишүүн байгууллага, клубийн тамирчид Допингийн дүрэм зөрчсөн
- Монгол улсын хууль тогтоомжийг зөрчсөн
- Гишүүнчлэлийн жил бүрийн татвараа хугацаанд нь бүрэн төлөөгүй
- МПХ-ны арга хэмжээнүүдэд оролцдоггүй, эсвэл сул оролцдог
- Хүндэтгэх шалтгаангүй нэг жилийн хугацаанд холбооны үйл ажиллагаанд оролцоогүй, хуваарьт зохион байгуулсан арга хэмжээнд 2 болон түүнээс дээш оролцоогүй

14.1.1 Гишүүнчлэлээс түдгэлзүүлэх эсэх асуудлыг ерөнхийлөгч, удирдах зөвлөлийн санаачилгаар удирдах зөвлөлийн хурлаар эцэслэн, хугацааг тогтоон хэрэгжүүлнэ

14.1.2 МПХолбооны бусад гишүүд гишүүнчлэлийг түдгэлзүүлсэн гишүүнтэй спортын чиглэлээр харилцаа хөгжүүлэхгүй

14.1.3 Түдгэлзүүлсэн шалтгааныг шаардсан хугацаанд арилгаагүй, шаардсан хугацаанд хариу өгөөгүй тохиолдолд гишүүнчлэлийг түдгэлзүүлсэн гишүүний эрхийг тухайн жилд дуусгавар болно

14.2 **Гишүүнчлэлээс хасах:**

- Гишүүн байгууллага, хувь гишүүний зүгээс үйл ажиллагаа явуулах боломжгүй болсноо мэдэгдэн гишүүнчлэлээс хасахыг хүссэн хүсэлт гаргасан
- Гишүүн байгууллага, хувь гишүүн нь МПХ-ны дүрэм, журам, МПХ-ны удирдах зөвлөлийн хурал, бүх гишүүдийн хурлаас гаргасан шийдвэрийг зөрчсөн
- Холбооны гишүүний ёс зүйг зөрчсөн;
- Гишүүнчлэлийн жил бүрийн татвараа хугацаанд нь төлөөгүй

14.2.1 МПХ-ны нэр хүндэд сөргөөр нөлөөлсөн, сөргөөр нөлөөлөхийг оролдсон аливаа үйлдэл, дүрэм, журмыг зөрчсөн гишүүн байгууллага, хувь гишүүний гишүүнчлэлийг нэг талын санаачилгаар энэхүү дүрмийг баримтлан удирдах зөвлөлийн хурлаар эцэслэн цуцална

14.2.2 МПХ-ноос хассан шийдвэрийг Ерөнхий нарийн бичгийн дарга тухайн гишүүн байгууллага, хувь гишүүнд албан бичгээр мэдэгдэнэ.

ТАВ ДУГААР БҮЛЭГ:
АРВАН ДӨРӨВ ДҮГЭЭР ЗҮЙЛ: МПХ-НЫ ДҮРМИЙГ МӨРДӨХ, НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, ТАТАН БУУЛГАХ

14.1 МПХ-ны дүрмийг удирдах зөвлөлийн хурлаар баталж, баталсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж мөрдөгдөнө

14.2 МПХ-г татан буулгах асуудлыг хуульд заасан үндэслэл, шүүхийн шийдвэр болон бүх гишүүдийн хурлаар шийдвэрлэх бөгөөд бүх гишүүдийн хурлын оролцогчдын олонхын саналаар шийдвэрлэнэ

14.3 Татан буугдсан тохиолдолд эд хөрөнгийн тооцоог нарийвчлан хийж, хуульд зааснаар шийдвэрлэнэ

14.4 Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг улс орны эдийн засгийн нөхцөл байдал, МПХ-ны гүйцэтгэж байгаа чиг үүргийн өөрчлөлт, шаардлага зэргийг харгалзан МПХ-ын удирдах зөвлөлийн олонхын саналаар шийдвэрлэнэ

ЗУРГАА ДУГААР БҮЛЭГ:
АРВАН ТАВ ДУГААР ЗҮЙЛ: ХӨРӨНГӨ, САНХҮҮ

15.1 МПХ нь өмч, хөрөнгөтэй байж болно

15.2 **МПХ-ны орлого дараах эх үүсвэрээс бүрдэнэ Үүнд:**

15.1.1 Гишүүнчлэлийн татвар, байгууллага болон хувь гишүүд

15.1.2 Гадаад, дотоодод болох спортын тэмцээн, бусад арга хэмжээнд оролцох, зохион байгуулахад төр, засаг болон аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, ивээн тэтгэгч, иргэд болон гишүүдээс оруулсан санхүүжилт, санхүүгийн дэмжлэг

15.1.3 Гадаад, дотоодын байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс өгсөн буюу хандивласан техник тоног төхөөрөмж, далавч, суудал, каск хэрэгсэл, хувцас үндэсний болон гадаад валют

15.1.4 Дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон аж ахуйн үйл ажиллагаанаас олсон орлого

15.1.5 Төр, засгийн болон бусад байгууллагын захиалгаар гэрээгээр гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний орлого

15.1.6 Дотоодын тэмцээний хураамжийн орлого

15.1.7 Спортын маркетингийн үйл ажиллагааны орлого

15.1.8 МПХ нь хууль, тогтоомжийн дагуу санхүүгийн тайлан тэнцлээ хуулийн хугацаанд холбогдох байгууллагад гаргаж өгнө

15.1.9 МПХ ны тайлан тэнцэл нь ил тод байна

АРВАН ЗУРГАА ДУГААР ЗҮЙЛ: МПХ-НЫ ОНЦЛОГ ЗҮЙЛ

16.1 МПХ нь бэлгэдэл /лого 3 өнгөөс ихгүй/, туг, тэмдэг, данс, вэб хуудас, цахим шуудан, албан бичгийн нүүртэй байна

16.2 МПХ-ны бэлгэдэл, тугийн загвар, хэрэглэх журмыг МПХ-ны удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн батална

16.3 МПХ-ны бэлгэдлийг МПХ ны гишүүд нь туг, зурагт хуудас, ном, албан бичиг болон веб хуудас, зүүлт, хаяг, медаль, дурсгалын тэмдэг, дарцаг, багийн бүрэлдэхүүний болон шүүгчдийн хувцас, хэрэглэл, ном сэтгүүл зэрэгт хэрэглэх бөгөөд МПХ-ны гишүүн клуб болон албан ёсны гэрээт түнш байгууллага мөн нэгэн адил хэрэглэж болно

16.4 МПХ-ны шигшээ багийн бүрэлдэхүүн, шүүгчид нь дотоодод болох тэмцээнд холбооны лого, МПХ-ны шүүгч гэсэн бичиг бүхий дүрэмт болон багийн хувцастай байна. Дүрэмт хувцасны загвар, хэрэглэх журмыг удирдах зөвлөл тогтооно

16.5 МПХ нь өөрийн нэрэмжит шагнал, сургалтын хөтөлбөр, сургалтын гарын авлагатай байна